

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1079
танай _____-ны № _____-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох "Их Эв нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

Дүгнэлт

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор "Их Эв нам"-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Их Эв нам"-ын мөрийн хөтөлбөр /.....15.....хуудас/-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ



Z:\Yawsan_Bichigl2024\0420 GNAG-3.Docx

0001030664

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан дүгнэлт гаргахтай холбогдуулан
Үндэсний аудитын газарт 2024 оны УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Их эв намаас хүргүүлэх мөрийн хөтөлбөр

№	Нам эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ	“Алсын хараа - 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого	Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүжилт шаардагдах, зардал гаргахаар тусгасан эсэх		Тайлбар
			Тийм*	Үгүй	
	1	2	3	4	
I. ШИНЭЧЛЭХ					
1.	<u>Улс төрийн шинэчлэл:</u>	2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа 5.1			
	Төрийг цомхон, чадварлаг болгох бодлогыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх.	зүйл заалт 5.2	Үгүй		
	Бүх шатны төрийн албан хаагчийг мэргэжлийн тогтмол давтан сургалттай болгох.	зүйл заалт 5.2, 5.4	Үгүй		Байгаа бүтэц, тогтолцоог ашиглах
	Бүх шатны төрийн албан хаагчийг тусгай хөтөлбөрөөр байнга соён гэгээрүүлэх, тэдний ёс суртахуун, сахилга батыг сайжруулах.	АТА9693 ө. 902303056 зүйл заалт 5.2, 5.4	Үгүй		Байгаа бүтэц, тогтолцоог ашиглах
	Орон нутгийн өөрийн удирдлагын системийг улам боловсронгуй болгох.	зүйл заалт 8.1.7, 8.1.10	Үгүй		
	Орон нутгийн бие даан оршин тогтнох чадварыг эрс нэмэгдүүлэх.	зүйл заалт 8.1.1, 8.1.9	Үгүй		




<p>2. <u>Нийгмийн шинэчлэл:</u></p>	<p>2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа</p>		
<p>Хүн төвтэй нийгмийг цогцлоох бодлогыг хэрэгжүүлэх.</p>	<p>зүйл заалт 5.5.1, 5.5.7</p>	<p>Үгүй</p>	
<p>Нийгмийн тэргүүлэх чиглэлийг уул уурхай биш, боловсрол, гэгээрлийн салбар болгох бодлогыг хэрэгжүүлэх.</p>	<p>зүйл заалт 1.5</p>	<p>Үгүй</p>	
<p>Оюун санаа, эрдэм мэдлэг, авъяас чадвар, үүрэг хариуцлага, шударга үнэний үнэлэмжинд суурилсан нийгмийг байгуулах.</p>	<p>зүйл-заалт 1.4.6, 1.2</p> 	<p>Үгүй</p>	
<p>Нийгэм дэх хамгийн дээд үнэ цэнэ бол эрүүл чийрэг, ендөр боловсролтой, дээд гэгээрэлтэй, хүнлэг энэрэнгүй, үнэнч шударга, эх оронч, үүрэг хариуцлагатай, баг журамтай монгол хүн байх тогтолцоог бүрдүүлэх.</p>	<p>зүйл заалт 1.4.6, 1.5, 2.5</p>	<p>Үгүй</p>	
<p>Хүний эрх чөлөө болон нийтийн эрх чөлөөг эрхэмлэн дээдэлдэг ардчилал, ардчилсан нийгмийг цогцлоох.</p>	<p>зүйл заалт 5.1.5, 5.1.7, 5.1.13</p> 	<p>Үгүй</p>	

<p>3. <u>Эдийн засгийн шинэчлэл:</u></p>	<p>2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа 4.2</p>		
<p>Хүн бүхэн үйлдвэрлэгч, өрх бүхэн үйлдвэрлэгч байх тогтолцоог бий болгох.</p>	<p>зүйл заалт 4.2.1</p>	<p>Үгүй</p>	
<p>Баг, сум, хороо, аймаг, дүүрэг бүхэн үйлдвэрлэгч байх тогтолцоог бий болгох.</p>	<p>зүйл заалт 4.2.1</p>	<p>Үгүй</p>	



<p>Уул уурхайд суурилсан эдийн засгаас олон тулгуурт эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> - мал аж ахуйд суурилсан эдийн засаг хөгжүүлэх - үндэсний үйлдвэрлэлд суурилсан эдийн засаг хөгжүүлэх - мэдлэгт суурилсан эдийн засаг хөгжүүлэх - оюун ухаанд суурилсан эдийн засаг хөгжүүлэх - аялал жуулчлалд суурилсан эдийн засаг хөгжүүлэх - технологид суурилсан эдийн засгийг хөгжүүлэх. 			<p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p>	
<p>4. Хариуцлагын шинэчлэл:</p> <p>Хүн бүр, хуулийн этгээд бүрийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, сайжруулахын тул улам боловсронгуй хариуцлагын тогтолцоог санаачлах, хуульчлах, хэрэгжүүлэх.</p> <p>Хувийн хариуцлагын тогтолцооноос гадна хамтын хариуцлагын тогтолцоог бий болгох.</p> <p>Хувийн болон хамтын хариуцлагын цогц хууль санаачилж батлуулах.</p> <p>УИХ – ын гишүүдийн халдашгүй байдлыг хамгаалсан хуулийн заалтыг цуцлуулах.</p>	<p>2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа 2.3</p> <p>зүйл заалт 2.3.1, 2.3.5</p> <p>зүйл заалт 2.3.2, 2.3.3</p> <p>зүйл заалт 2.3.2, 2.3.4</p>		<p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p>	




(Handwritten signature in blue ink)

<p>5. Татварын шинэчлэл:</p>	<p>2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа 4.1</p>		
<p>Хүн амын орлогын албан татвар бус хүн амын татвар авдаг тогтолцоо бий болгох: хүн амыг хүүхэд багачууд, идэр залуу, ахмад үе гэсэн гурван хэсэгт ангилаад, ангилал бүр ижил тэнцүү хэмжээний татвар төлдөг буюу насны ангиллаар ялгаатай мөртөө ангилал дотроо ижил тэнцүү хэмжээтэй татвар төлдөг тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх.</p>	<p>зүйл заалт 4.1.1, 4.1.15</p>	<p>Үгүй</p>	
<p>Тансаг хэрэглээний бараа бүтээгдэхүүний НӨАТ – ын хувь хэмжээг нэмэгдүүлэх.</p>	<p>зүйл заалт 4.1.11</p>	<p>Үгүй</p>	
<p>Албан татварын хэмжээг нэмэхгүй, шинээр татвар бий болгохгүй.</p>	<p>зүйл заалт</p>	<p>Үгүй</p>	



<p>II. ӨӨРЧЛӨХ</p>			
<p>1. <u>Эрүүл мэндийн салбар дахь өөрчлөлт:</u></p>	<p>2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа 2.2</p>		
<p>Бүх эмнэлгийн орчин нөхцөл, техник технологи, нөөц хангамж, эмчилгээ үйлчилгээг чанарын дээд түвшинд хүргэх.</p>	<p>зүйл заалт 2.2.1, 2.2.5</p>	<p>Үгүй</p>	<p>000000004</p>

Handwritten signature

	2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа 2.1		
<p>2. Боловсролын салбар дахь өөрчлөлт:</p> <p>Боловсролын салбарыг гэгээрлийн салбар болгох ажлыг хууль эрх зүйн хүрээнд хийх.</p>	зүйл заалт 2.1	Үгүй	
<p>Бүх шатны сургуулийн сургалт, сургалтын орчныг чанарын ба нийгмийн шаардлагыг өндөр түвшинд хангаж, дэлхийн түвшинд хүргэх.</p>	зүйл заалт 2.1.1, 2.1.41	Үгүй	
<p>Хүнийг мэргэжилтэн болгон бэлдэж буй өнөөгийн тогтолцоог хүнийг сайн мэргэжилтнээс гадна жинхэнэ хүн, жинхэнэ монгол хүн буюу зөв, үнэн, шударга, ариун, эх оронч монгол хүн болгож бэлддэг тогтолцоо болгож өөрчлөх.</p>		Үгүй	
<p>Хүнийг ажил мэргэжилд бэлдэж байгаа одоогийн тогтолцоог хүнийг ажил мэргэжилд төдийгүй амьдралд бэлтгэдэг тогтолцоо болгох.</p>	зүйл заалт 1.1, 1.3	Үгүй	
<p>Хүнийг юуны өмнө хүншүүлэх, улмаар хүмүүжүүлэхэд онцгой ач холбогдолтой монгол хэл, уран зохиол, түүх, монгол уламжлалт соёл, ёс заншилтай холбоотой хичээлүүдийн заах цагийг нэмэгдүүлэх.</p>	зүйл заалт 1.4, 1.5	Үгүй	
<p>Хүнийг соён гэгээрүүлэх болон иргэншүүлэхэд онцгой ач холбогдолтой монгол суу ухааны хичээлийг бүх шатны боловсролын агуулагд багтаан заах.</p>			






<p>3. Хүнийг өөрчлөх:</p>	<p>2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p>						
<p>Сүүлийн 30 жилд монгол хүний хүн ёс, хүн чанар, хүн сэтгэл, хүнлэг сэтгэл, ёс суртахуун, үүрэг хариуцлага, нүнжиг жудаг, баг журам, ноён нуруу нэн ихээр алдагдаж байгаа тул монгол хүнийг дахин сургах, дахин боловсруулах, дахин хүмүүжүүлэх ажлыг өргөн далайцтай, өндөр чанартай хийх.</p>	<p>зүйл заалт 2.1</p>						
<p>Ард түмнийг бүх нийтээр нь албан журмаар соён гэгээрүүлэх.</p>	<p>зүйл заалт 2.1.5, 2.1.17</p>						
<p>Уламжлал, шинэчлэлийг хослуулсан 21 - р зууны зөв, үнэн, шударга, ариун монгол хүнийг төлөвшүүлэх.</p>	<p>зүйл заалт 2.1.23 ATA969J 902303</p>						
<p>Нийгмийн үүрэг хариуцлагаа гүн ухамсарласан, ёс суртахуун, ёс журам, ёс жудаг, баг журам бүхий монгол хүнийг дахин хүмүүжүүлэх.</p>	<p>зүйл заалт</p>						
<p>Эв хамтач, эвсэг нийтгэгч, хүн чанар, хүн сэтгэл, хүнлэг сэтгэлтэй, нинжин энэрэнгүй монгол хүн</p>	<p>зүйл заалт</p>						
<p>Эмэгтэйчүүдийн боловсрол, соён гэгээрэл, хөгжлийн түвшинг дээшлүүлэх.</p>	<p>зүйл заалт</p>						
<p>Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшинд оролцох оролцоог нэмэгдүүлэх.</p>	<p>зүйл заалт</p>						

0000000000




	2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа		
<p>4. Хууль, эрх зүй:</p> <p>Хуулийн дарангуйллын зарим илрэл, хэлбэр болсон эрүүдэн шүүлт, хэлмэгдүүлэлт, хууль бус үйл ажилагаануудыг бүрэн халах бодлогыг хэрэгжүүлэх.</p>	<p>зүйл заалт 5.1.1,</p>	<p>Үгүй</p>	
<p>Хууль, шүүхийн байгууллага болон түүний ажилтан, албан хаагчдыг гарцаагүй шударга ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тул хамаарах хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, зохих хуулийг санаачлах.</p>	<p>зүйл заалт 5.6.2,</p>	<p>Үгүй</p>	
<p>Хорих ангиудын засан хүмүүжүүлэх үйл ажиллагаанд соён гэгээрүүлэх ажлыг нэвтрүүлэх.</p>	<p>зүйл заалт 5.6.1</p>	<p>Үгүй</p>	
<p>Хуулийн байгууллагуудын бүх шатны ажилтан, албан хаагчдад зориулсан үүрэг хариуцлагаа ухамсарлах, ёс суртахууныг эрхэмлэх, шударга ёсыг дээдлэхэд төлөвшүүлэх тусгай зорилтот соён гэгээрүүлэх ажил хийх.</p>	<p>зүйл заалт 5.6.6 ATA9693 90230305</p>	<p>Үгүй</p>	<p>Байгаа бүтэц, тогтолцоог ашиглах.</p>
<p>5. Шударга ёс:</p>	<p>2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа</p>		
<p>Ёс суртахууны тухай хууль санаачилж батлуулах.</p>	<p>зүйл заалт 1.4.6, 5.4.11</p>	<p>Үгүй</p>	
<p>Хариуцлагын тухай хууль санаачилж батлуулах.</p>	<p>зүйл заалт 4.2.20, 5.2.16, 5.4.16</p>	<p>Үгүй</p>	
<p>Шударга ёсны тухай хууль санаачилж батлуулах.</p>	<p>зүйл заалт 5.6, 5.6.2</p>	<p>Үгүй</p>	


00009007

Ш. ЗАСАЖ САЙЖРУУЛАХ							
1. <u>Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээ:</u>	2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа						
Шинжлэх ухаан, технологийг Монгол улсын тогтвортой хөгжлийг хангах, амьдралын чанар, үндэсний чадамж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, инновацийг дэмжиж үйлдвэрлэлд нэвтрүүлэх, соён гэгээрэлд суурилсан улс төр, соён гэгээрэлд суурилсан нийгэм, соён гэгээрэлд суурилсан эдийн засаг, соён гэгээрэлд суурилсан оршин амьдрахуй бүрэлдэн тогтох нөхцлийг бий болгоход чиглүүлэн хөгжүүлэх.							
Шинжлэх ухааны онол, мэдлэгийг хялбаршуулж, олон нийтийг соён гэгээрүүлэх үндсэн арга хэрэгсэл болгох.							
Шинжлэх ухааны салбар дахь төсвийн хуваарилалтыг нэмэгдүүлэх замаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг чанаржуулах, үр дүнг улам нэмэгдүүлэх.			зүйл заалт	Тийм			
2. <u>Соёл гэгээрэл:</u>	2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа						
Ард түмнийг бүх нийтээр нь албан журмаар соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулан батлуулах.			зүйл заалт 5.6.1				
Хөтөлбөрийн дагуу ард түмнийг байнга соён гэгээрүүлэх.			зүйл заалт 5.6.1				Байгаа бүтэц, тогтолцоог 



Нийгмийн салбарууд, мэргэжлийн салбаруудын хүрээнд тусгай хөтөлбөрт соён гэгээрүүлэх ажлуудыг тасралтгүй хийх.	зүйл заалт 5.6.1	Үгүй	Байгаа бүтэц, тогтолцоог ашиглах
<p>3. Соёл:</p> <p>Биет болон биет бус монгол соёлын өвүүдийг хамгаалах гол арга нь ЮНЕСКО – гийн соёлын өвд бүртгүүлэх төдий явдал бус, харин үеэс үед заан сургах, дамжуулан өвлүүлэх, амьдралд байнга хэрэглэж – соёлыг амьд байлгах явдал хэмээх бодлогыг хэрэгжүүлэх.</p> <p>Биет болон биет бус монгол соёлын өвүүдийг судлах, хамгаалах, сэргээх ажлуудыг эрчимжүүлэх.</p> <p>Монгол уламжлалт соёл, соёлын өвүүдийг бүх төрлөөр хамгаалах, судлах, сэргээх, өвлүүлэх, гадаад ба дотоодод сурталчлан таниулах ажлуудыг эрчимжүүлэх.</p>	<p>2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа</p> <p>зүйл заалт 1.1.12, 1.5.3, 1.5.9</p>  <p>зүйл заалт 1.1.9</p> <p>ATA969-9023036</p> <p>зүйл заалт 1.1.19, 1.2.4</p>	Үгүй	
<p>4. Шашин шүтлэг:</p> <p>Аль ч шашны үйл ажиллагааг соён гэгээрүүлэх зорилгод нийцүүлэх.</p>	зүйл заалт	Үгүй	
<p>5. Байгаль экологи:</p> <p>Ногоон хөгжлийн бодлого нь Монгол улсын оршихуй, хөгжихүйн тулгуур байсан уламжлалыг бүх талаар эрчимтэй сэргээх.</p>	<p>2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа 6.1</p> <p>зүйл заалт 6.1.1, 6.1.2, 6.1.6</p>	Үгүй	Төсвийн зохицуулалт, гадаад дотоод тусламж, хөрөнгө оруулалтаар



Монгол улсын газар нутаг, байгаль, цаг уурын бүрэн бүтэн байдлыг бүх талаар эргэн сэргээх.	зүйл заалт 6.2.19		Үгүй	
Байгаль экологийг хамгаалах төдийгүй усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эх газруудыг бүрэн хамгаалалтанд авах.	зүйл заалт 6.1.4	Тийм		Төсвийн зохицуулалт, гадаад дотоод хөрөнгө оруулалт, тусламжаар
Хүн амын ундны ус, ахуйн болон бэлчээрийн малын ундны усны эх үүсвэрийг онцгойлон хамгаалах, тэдгээрийг аливаа үйлдвэрлэл, уул уурхайд ашиглуулахгүй байх.	зүйл заалт 6.3.6.3.1 	Тийм		Төсвийн зохицуулалт, гадаад дотоодын хөрөнгө оруулалт, тусламжаар
Байгаль орчин, газар зүй, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох үндэсний чадавхийг бүх талаар бүрдүүлж, байгалийн элдэв гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх.	зүйл заалт 6.2.15, ATA9693 2021 - 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиглагаа		Үгүй	Байгаа бүтэц, тогтолцоог ашиглах
6. Уул уурхай:				
Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд уул уурхайн эдийн засагт эзлэх байр суурь, нөлөөг үе шаттайгаар бууруулах.	зүйл заалт 4.2.11		Үгүй	
Ард түмний санал асуулгаар шийдвэрлэсэн уул уурхайн ашиглалтын хуваарь гаргаж хэрэгжүүлэх.	зүйл заалт		үгүй	
Ашиглаж буй болон ашиглах уурхайнуудын хувьд боловсруулах үйлдвэрүүдийг бүх шатанд барьж ажиллуулах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.	зүйл заалт 4.2.12		Үгүй	Энэхүү хөтөлбөрийн Хөдөлмөр эрхлэлт хэсэг дэх 2 – р заалттай уялдуулан хэрэгжүүлэх





00000010

<p>7. Мал аж ахуй:</p> <p>Мал, малчин, мал аж ахуйг дэмжих үндэсний цогц бодлого, үндэсний цогц хөтөлбөрийг боловсруулж, баглуулах.</p> <p>Малын түүхий эдийг боловсруулах үйлдвэрүүдийг шинжлэх ухааны тооцоо, судалгааны үндсэн дээр маш нарийн төлөвлөгөөтэй барьж байгуулж, ажиллуулах ажлыг үе шаттайгаар хийх.</p>	<p>2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p> <p>зүйл заалт 8.1.9, 8.3.5</p> <p>зүйл заалт 8.3.4</p>	<p>Энэхүү хөтөлбөрийн Хөдөлмөр эрхлэлт хэсэг дэх 2 – р заалттай уялдуулан хэрэгжүүлэх</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p>	
<p>8. Аж үйлдвэр:</p> <p>Олон тулгуурт эдийн засгийн хөгжлийн хүрээнд Монгол улсыг аж үйлдвэр - хөдөө аж ахуй - аялал жуулчлалын орон болгох.</p> <p>Хүнс, хөнгөн үйлдвэр, боловсруулах үйлдвэр, хүнд үйлдвэрийг хурдацтай хөгжүүлэх бодлого, үндэсний хөтөлбөрийн илүү боловсронгуй хувилбарыг боловсруулж хэрэгжүүлэх.</p>	<p>2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p> <p>зүйл заалт 4.4.18</p> <p>АТАҮБҮС 9023030, зүйл заалт 4.2.1</p>	<p>Энэхүү хөтөлбөрийн Хөдөлмөр эрхлэлт хэсэг дэх 2 – р заалттай уялдуулан хэрэгжүүлэх</p> <p>Төрийн бодлогоор</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p>	
<p>ХАА – н үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх тусгай бодлого боловсруулж баглуулах.</p> <p>Иргэдийн эрхэлж буй жижиг, дунд үйлдвэрлэлийг төрийн тусгай бодлогоор дэмжиж хөгжүүлэх.</p> <p>Дэлхийн зах зээлд нийлүүлэх экспортын бүтээгдэхүүний төрөл, тоо, чанарыг эрчимтэй нэмэгдүүлэх бодлогыг боловсруулж баглуулах.</p>	<p>зүйл заалт 4.4.10, 9.5.9</p> <p>зүйл заалт 4.4.1</p> <p>зүйл заалт 6.4.7</p>	<p>Энэхүү хөтөлбөрийн Хөдөлмөр эрхлэлт хэсэг дэх 2 – р заалттай уялдуулан хэрэгжүүлэх</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p>	



	2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа		
9. <u>Аялал жуулчлал:</u>	2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа		
Байгалийн аялал жуулчлалыг улам эрчимтэй хөгжүүлэх.	зүйл заалт 4.2.1, 4.2.46	Байгаа бүтэц, тогтолцоог ашиглах	Байгаа бүтэц, тогтолцоог ашиглах
Үндэсний соёл, ёс заншлын аялал жуулчлалыг хөгжүүлэх.	зүйл заалт 1.1.13, 1.2.10, 1.5.6	Байгаа бүтэц, тогтолцоог ашиглах	Байгаа бүтэц, тогтолцоог ашиглах
10. <u>Банк, санхүү:</u>	2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа		
Банкны салбарыг олон улсын өрсөлдөөнд оруулах.	зүйл заалт	Төрийн бодлогоор	
11. <u>Хөдөөгийн хөгжил:</u>	2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа	Тийм	Хувийн хэвшлийг дэмжих замаар
Хөдөөгийн хүн амын орлогыг эрс нэмэгдүүлэхийн тул хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийг олон төрөл, хэмжээгээр худалдан авдаг хөдөө аж ахуйн биржүүдийг орон нутагт ажиллуулах.	зүйл заалт АТА969; 90230305	Тийм	Хувийн хэвшлийг дэмжих замаар
12. <u>Хөдөлмөр эрхлэлт:</u>	2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажилагаа		
Энэхүү хөдөлмөрийн “Аж үйлдвэр” гэсэн хэсэгт тусгагдсан олон төрлийн аж үйлдвэрийг барьж байгуулж, ажиллуулах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх.	зүйл заалт	Төсвийн зохицуулалт, ЖДҮ сан, бусад сан, гадаад дотоод хөрөнгө оруулалт, зээл, тусламжаар	Төсвийн зохицуулалт, ЖДҮ сан, бусад сан, гадаад дотоод хөрөнгө оруулалт, зээл, тусламжаар
Компьютер, программ хангамж, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан зэрэг оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг боловсруулах.	зүйл заалт	Тийм	Тийм
Хувиараа бизнес эрхлэлтийг бүх талаар төрийн бодлогоор дэмжих.	зүйл заалт	Тийм	Тийм

	2021 – 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа		
<p>13. <u>Нийгмийн хамгаалал:</u></p> <p>Хавтгайрсан халамжийн бодлогоос тагталзах бодлогыг хэрэгжүүлэх.</p> <p>Одоо хэрэгжиж байгаа нийгмийн хамгааллын бүх хөтөлбөр, үйл ажиллагааг улам боловсронгуй, оновчтой, үр дүнтэй болгох.</p> <p>Иргэдийн бие даан амьдрах, амьдрал ахуйгаа бие даан авч явах чадвар болон нийгмийн нөхцлийг үе шаттайгаар сайжруулах.</p>	<p>зүйл заалт 2.5.22</p> <p>зүйл заалт 2.3.1, 7.2.16</p> <p>зүйл заалт 2.3.2, 3.1</p>	<p>Үгүй</p> <p>Үгүй</p> <p>Үгүй</p>	<p>Төрийн бодлого, ЖДҮ – ийн сан, бусад санг оновчтой ашиглах замаар</p>
<p>14. <u>Гэр бүл:</u></p> <p>Нийгмийн хамгааллын хүрээнд гэр бүлийн зөвлөлгөө өгөх төвүүдийг судалгаа, тооцооны үндсэн дээр хүртээмжтэйгээр байгуулж, ажиллуулах.</p> <p>Гэр бүлийн хүчирхийллийн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн соён гэгээрлийн ажлуудыг үе шаттайгаар явуулах.</p>	<p>2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p> <p>зүйл заалт 1.2.1, 2.1, 2.3</p> <p>зүйл заалт 2.3.2, 2.3.12</p>	<p>Тийм</p>	<p>Төсвийн зохицуулалтаар</p> <p>Байгаа бүтэц, тогтолцоог ашиглах</p>
<p>15. <u>Гадаад харилцаа:</u></p> <p>Хөрш орнууд болох ОХУ, БНХАУ – тай харилцах харилцан хүндэтгэлтэй, харилцан ашигтай, найрсаг харилцааг гадаад бодлогод тэргүүн зэрэгт авч үзэх.</p> <p>Дэлхийн бусад орнуудтай гуравдагч хөршийн харилцан хүндэтгэлтэй, харилцан ашигтай, найрсаг харилцааг бэхжүүлж, хөгжүүлэх.</p>	<p>зүйл заалт 1.5.5</p> <p>зүйл заалт 1.5.5</p>	<p>Үгүй</p> <p>Үгүй</p>	

IV. УСТГАХ					
1.	Монгол улс, үндэстний эрх ашиг, аюулгүй байдалд заналхийлсэн, улсаас урвасан аливаа үйл ажиллагааг таслан зогсоох.	Нийцсэн			Үгүй
2.	Монгол улс, үндэстний эрх ашиг болон шударга ёсонд халтай аливаа үзэгдлийг таслан зогсоох.	 Нийцсэн			
3.	Монгол улс, үндэстний эрх ашгаас дээгүүр давсан хувийн болон компанийн, хүн ёсны аливаа харилцааг таслан зогсоох.	Нийцсэн			Үгүй
4.	Нийгмийг хүчтэй цочрол, айдас түгшүүрт автуулдаг жигшүүрт гэмт үйлдлүүдийг таслан зогсоох.	 Нийцсэн			Үгүй
5.	Нийгмийн доторх хүчирхийлэл, доромжлол, гүтгэлэг, дээрэм, булаалт, худал хэлэх, хууран мэхлэх, нэр хүндэд халдах, мансуурах, хар тамхинд донтох, биеэ үнэлэх, архидан согтуурах зэрэг хүнд гэмт үйлдлүүдийг таслан зогсоох.	Нийцсэн			Үгүй
6.	Нийгэмд гарч байгаа гэмт хэргүүдийн тоог бууруулах.	Нийцсэн			Үгүй
7.	Хуулийг шударга бусаар хэрэглэх, ашиглах явдлыг таслан зогсоох.	Нийцсэн			Үгүй



